

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
Боловсролын зээлийн сан
2025 оны эхний хагас жил

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
УИХ-ын тогтоол							
1	1	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	3.б. б/хүүхдийн асрамж халамжийн төвөөс гарч байгаа өнчин хүүхдийг ажлын байр, орон байртай болоход бодитой дэмжлэг үзүүлэх, тэдгээр хүүхдийг их, дээд сургуульд суралцахад боловсролын зээлийн санхүүжилтээр үнэ төлбөргүй суралцуулах, суралцагчийн тэтгэлгийн асуудлыг хамтад нь шийдвэрлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	1. БЗС-ийн журмын шинэчлэлтээр ХБИ-ийн суралцах иргэдийг боломжийг нэмэгдүүлсэн. 2. БЯ-ны 2024-2025 оны хичээлийн жилд яам, харьяа байгууллагын албан хаагчдад “Монгол дохионы хэлний харилцааны анхан шатны мэдлэг чадвар олгох сургалт”-д ахлах мэргэжилтэн Ч.Гэрэлчимэг, Доржсүрэн хамрагдаж гэрчилгээ авсан. 3. ЗГ-ын 2025 оны 04 сарын 30-ны өдөр батлагдсан 215 дугаар тогтоолын зорилтот бүлэгт чиглэсэн хэсгүүдийг харааны бэрхшээлтэй иргэнд зориулан МХҮХ-той хамтран брайль үсгээр хэвлүүлэн мөн аудио хэлбэрт оруулж сангийн вэйб хуудсанд байршуулан харааны бэрхшээлтэй хүмүүсд мэдээллийг тэгш хүргэх боломжийг бий болгосон. 4. БЗС-ийн цахим хуудсаас мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлж, ХБИ-дэд өөртөө тохируулан "үсэг өнгөө өөрчлөх" тохиргоо хийсэн 5. ХБХХЕГ-аас ирсэн хамтран ажиллах тухай албан бичгийн дагуу МУИС-ийн хэлэлцүүлэгт оролцож, хамтран ажиллаж	Хэрэгжсэн	Хэрэгжсэн	

		2024-05-02 Дугаар 2024_37		боловсролын зээлийн сангийн мэдээлэл Г. Нандинцэцэг, Ч. Гэрэлчимэг хүргэж, оролцогчдын асуултад хариулав. 6. Хөгжлийн бэрхшээлтэй 392 суралцагчдад 993.3 сая төгрөг, 38 суралцагчдад 25.2 сая төгрөг, бүтэн өнчин 624 суралцагчдад 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Үүнээс: 2025 оны Засгийн газрын 215 дугаар тогтоолоор 2025 онд Олон улсын Улаанбаатар их сургуулийн бакалаврын хөтөлбөрийн 4 суралцагчдад 9.1 сая, Сити ИС-ийн бакалаврын хөтөлбөрийн 2 суралцагчдад 7.3 сая, Этүгэн их сургуулийн 1 суралцагч 2.8 сая төгрөгийн санхүүжилт нийт 7 суралцагчдад 19.1 сая төгрөгийн санхүүжилт асрамжийн газрын бүтэн өнчин суралцагчдад олгосон. 7.ХБИ-ийн гадаадад суралцуулах сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан Хавсралт : 1 файл			
УИХ-ын байнгын хорооны тогтоол							
2	2	Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай 2024-11-06 Дугаар	1.2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)-	1.Ёс зүйн дэд зөвлөлийн гишүүдийг 1 удаагийн, Хэлтсийн дарга нарыг АТГ-ын сургалтад, хамруулсан. 2. Байгууллагын соёлыг дээшлүүлэх, албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагаараа олон нийтэд үлгэрлэх соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулсан. Ажлын албаны ажлын байран дахь сургалтыг "Санамсрын бясалгал, сэтгэлийн эрүүл мэнд" сэдвээр	Хэрэгжсэн	Хэрэгжсэн	

		2024_06 ЕЗДБХ	ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж, жил бүр тайлагнах;	"Жавзандамба хутагт" төвийн багш, гавж Д.Нямсамбуу зохион байгуулж, явуулсан. Нийт албан хаагчдын 88,8% буюу 24 албан хаагч хамрагдсан. 3. Улирлын үнэлгээний үзүүлэлтэд ТАХ-ийн ёс зүйн асуудлыг хуулийн хэрэгжилтийг оруулсан Хавсралт : 1 файл			
	3		1.3 . төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах.	1. Сангийн нийт албан хаагчдын дунд сонгон шалгаруулалт зарлаж, санал хураалтаар ёс зүйн дэд хорооны гишүүдийг сонгон шалгаруулсан. Сонгон шалгаруулсан албан хаагчдыг ажлын албаны даргын 2025-01-28-ны өдрийн А/12 тоот тушаалаар баталгаажуулсан. Ёс зүйн дэд хороо ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. 2. Боловсролын яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь Монгол Улсын Ёс зүйн хороотой хамтран ""ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, МЭДЛЭГ МЭДЭЭЛЛИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ"" сэдэвт сургалтад хамрагдахаар бэлтгэл хангасан." Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн	Хэрэгжсэн	
ЗГ-ын тогтоол							
3		Журам шинэчлэн	2. Энэ тогтоолын 1-д заасан журмын	"1.“Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын дагуу	Хэрэгжсэн	Хэрэгжсэн	

	4	батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_72	хэрэгжилтийг хангаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай. (1.“Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.)	2025 оны 06 сарын 24-ны байдлаар -Үндсэн үйл ажиллагааны зардалд 0.7 тэрбум төгрөг; - Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгээр дотоодын бэлтгэл хөтөлбөрөөр суралцаж буй 304 суралцагчийн 0.9 тэрбум төгрөг, гадаадын их дээд сургуульд суралцаж буй 707 /давхардсан тоо/ суралцагчийн 2025 оны 1-3 болон 4-6 сарын амьжиргааны зардал 2.4 тэрбум төгрөг, 230 суралцагчийн сургалтын болон дотуур байрны зардалд 1.2 сая ам,доллар; 259.5 мянган евро буюу 6.9 тэрбум төгрөг нийт 1241 /давхардсан тоо/ суралцагчид 10.2 тэрбум төгрөг; - Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид олгох буцалтгүй тусламжаар гадаад суралцаж буй суралцагчдын санхүүжилтийн тооцоог анхан шатны баримтад үндэслэн 2 суралцагчийн 63.1 мянган ам,доллар, 223.6 сая төгрөг; - Засгийн газрын (ЕС) тэтгэлгээр дэлхийн шилдэг их дээд сургуульд суралцаж буй суралцагчдын санхүүжилтийн тооцоог анхан шатны баримтад үндэслэн 24 суралцагчийн 21.6 мянган ам,доллар 18.0 мянган евро, нийт 1.7 тэрбум төгрөг; - Засгийн газар хоорондын гэрээгээр дотоодоос гадаадын их дээд сургуульд суралцаж 52 суралцагчийн 89.2 мянган ам,доллар нийт 0.3 тэрбум төгрөг; - Засгийн газрын гэрээгээр гадаадаас дотоодод суралцаж байгаа 223 суралцагчийн 1.2 тэрбум төгрөг; - Гадаадад суралцагсдын зээл:			
--	---	---	--	---	--	--	--

				дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ""Times Higher Education World University Rankings"" , эсхүл ""Academic Ranking of World Universities"" байгууллагын сүүлд тогтоосон эрэмбийн жагсаалтын эхний 20-д багтсан сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан бол мэргэжил харгалзахгүй, 21-50-д багтсан сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцаж буй 88 /давхардсан тоо/ суралцагчийн 1,063.5 мянган ам,доллар, нийт 3.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон."			
4	5	Журам шинэчлэн батлах тухай 2025-04-30 Дугаар 2025_215	2. 2.Энэ тогтоолын 1 -д заасан журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийгжил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж, зарцуулалтад нь хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсролын сайд П.Наранбаярт үүрэг болгосугай.	"Тус тогтоолын 2025 оны төсөвт багтаан 2024-2025 оны хичээлийн жилийн II /хавар/ улиралд дараах санхүүжилтийг олгож байна. Үүнд: 1. Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй 1257 суралцагчид 25.9 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Үүнд: сургалтын хөнгөлттэй зээл 80 суралцагчийн 3,7 тэрбум/төг, ерөнхийлөгчийн тэтгэлэг 1012 суралцагчийн 16.2 тэрбум/төг, Засгийн газрын тэтгэлэгт 26 суралцагчийн 1.7 тэрбум/төг, ХБИ-ний буцалтгүй тусламж 2 суралцагчийн 0.2 тэрбум/төг, Засгийн газар хоорондын тэтгэлэгт 57 суралцагчийн 0.4 тэрбум/төг, Дэлхийн шилдэг сургуулийн 80	Хэрэгжсэн	Хэрэгжсэн	

				суралцагч, 3.7 тэрбум төгрөгийн зээл олгосон. 2. Дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад сургалтын зээлээр суралцах 845 суралцагчид 1.9 тэрбум/төг, Засгийн газрын тэтгэлгээр суралцах 888 суралцагчид 2.2 тэрбум/төг, буцалтгүй тусламж, тэтгэлгээр 10027 суралцагчид 21.4 тэрбум/төг олгохоор тооцоолол хийгдсэн. Нийт 63 дээд боловсролын байгууллагын 11760 суралцагчид 25.5 тэрбум/төг-ийн санхүүжилт шилжүүлэхэд бэлэн болсон. 3. Ерөнхийлөгчийн-2100 хөтөлбөрт хэлний бэлтгэлд суралцаж буй 304 суралцагчид 0.9 тэрбум/төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон."			
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл							
5	6	2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2021-06-08 Дугаар 2021_34	ҮИИ.5.1. . Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасныг хэрэгжүүлж ажиллах, энэ хүрээнд өөрийн эрхэлсэн салбарын төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад нэг буюу түүнээс дээш тооны хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах зохион байгуулалтын арга	Боловсролын зээлийн санд ажлын бүтэн бус цагийн горимоор ажилладаг, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоосон акттай 1 албан хаагч байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасны дагуу албан хаагчийн цалингийн хэмжээ, албан тушаалын зэрэглэлийг бүтэн цагаар ажилладаг ажилтантай адил тогтоон, сард 2 удаа олгож байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 86 дугаар зүйлд заасны дагуу энэ албан хаагчийн долоо хоногт ажиллах цагийг 32 байхаар харилцан тохирч, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.	Хэрэгжсэн	Хэрэгжсэн	

			хэмжээ авахыг Засгийн газрын нийт гишүүдэд; ("Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар 2021-2024 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав.)			
6	7	2022 оны 7 дугаар сарын 5-ны өдөр 36 дугаар тэмдэглэл 2022-07-05 Дугаар 2022_36	ХХ.6.2. Газрын тос боловсруулах үйлдвэрт ажиллах нарийн мэргэжлийн инженер, техникийн ажилчдыг сургаж бэлтгэхэд шаардагдах эх үүсвэрийн асуудлыг судалж танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт;	"Газрын тос боловсруулах үйлдвэрт ажиллах нарийн мэргэжлийн инженер, техникийн ажилчдыг сургах чиглэлээр 2022-2025 он хүртэл дараах санхүүжилт олгож байна. Үүнд: 1. Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад Ерөнхийлөгчийн тэтгэлгийн газрын тосны инженер мэргэжлийн 2 суралцагчид 51.3 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. 2. Дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад сургалтын зээлээр Газрын тосны инженер, Газрын тосны боловсруулалтын технологи, Газрын тос хадгалалт, тээвэрлэлт мэргэжлээр 34 суралцагчид 83,9 сая/төг, Засгийн газрын тэтгэлгээр суралцах 1 суралцагчид 4.3 сая/төг олгосон байна. "	Хэрэгжсэн	Хэрэгжсэн

7	8	2023 оны 6 дугаар сарын 07-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2023-06-07 Дугаар 2023_24	XXV.14.. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан “Боловсролын зээлийн сан”-ийн хөрөнгөөр дэмжлэг, тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл олгох үйл ажиллагаанд процессын дахин инженерчлэл хийх тухай асуудлыг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцах хэрэгцээт, тэргүүлэх чиглэлийн мэргэжлийг жил бүр нээлттэй зарлаж, тус сангаас олгох зээл, тэтгэлэг, дэмжлэгийн үйл ажиллагаанд хүний оролцоог багасгаж, сонгон шалгаруулалтыг нэгдсэн журмаар, автоматжуулсан системээр зохион байгуулах боломжийг судлан танилцуулахыг	"Гадаадын дэд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдыг сонгон шалгаруулах ажлыг жил бүр нээлттэй зарлаж, тус сангаас олгох зээл, тэтгэлэг, дэмжлэгийн үйл ажиллагаанд хүний оролцоог багасгаж, сонгон шалгаруулалтыг нэгдсэн журмаар, автоматжуулсан системээр зохион байгуулахаар ажиллаж байна. Үүнд:1.2025 оны ЗГХ-ын гэрээгээр суралцуулах ажлаар Унгар, Болгар, Вьетнам, Казакстан, Куба гэсэн 5 орны сонгон шалгаруулалтыг 2025 оны 2-6 сард зохион байгуулж, сан болон яамны веб сайтад нээлттэй ил, тод зарлаж, ирүүлсэн материалд үндэслэн шалгаруулалт хийж БЯ-нд тайланг хүргүүлж, яам санд тус тус архивын нэгж бүрдүүлэн, СШ-ыг сангийн ААД ахалж, СЗТХ-ийн дарга нарийн бичгийн даргаар ажилласан. 2. БЗС-н санхүүжилтээр гадаадад ахисан түвшин, бакалаврт суралцуулах болон ХБИ-г сонгон шалгаруулалтыг сангийн болон яамны веб сайтад нээлттэй ил, тод зарласан.https://scholarship.elf.gov.mn цахим систем ашиглан материал хүлээн авах ажиллагааг зохион байгуулсан. . 3. 2025 оны сонгон шалгаруулах үйл ажиллагаанд хүний оролцоог багасгаж, автоматжуулсан цахим систем бий болгох зорилгоор бизнес анализ, процессын зураглал хийж, Боловсролын сайдын 2025 оны А/15 тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлаар	Хэрэгжсэн	Хэрэгжсэн	
---	---	--	--	--	-----------	-----------	--

			Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт тус тус даалгав.	хэлэлцэн, системийн архитектур боловсруулав. Үүний “Дижитал Кредит” ХХК-г хөгжүүлэгчээр сонгон шалгаруулсан. БЯ- ЦБГ, БМТТ, ҮДТ, БЗС хамтран хөгжүүлэлтийн орчин, системийн хэрэгцээ шаардлага, техникийн шийдэл, домэйн хаяг, аюулгүй байдлын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Монголын төрд байгаа мэдээллийг танилт нэвтрэлтийн “ДАН” системээр дамжуулан төрийн “ХУР” системээр дамжуулан авч, үнэлгээг автоматаар бодох шийдэл бүхий системийг хөгжүүлж, 2025.05.23-2025.06.22-нд 30 хоногт материал хүлээн авч 2025.06.15-.2025.06.30-ны хооронд 3 ажлын хэсэг СШ-ыг зохион байгуулж байна			
ЗГ-ын албан даалгавар							
8	9	2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024-01-12 Дугаар 2024_01	7.1.. Хүний хөгжлийн чиглэлээр: Монгол Улсын хүний нөөцийн чадавхийг сайжруулах, хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор Боловсролын зээлийн санг Боловсролын хөгжлийн сан болгож, холбогдох журмуудыг шинэчлэх арга хэмжээг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-	ЗГ-ын 2023.06.14-ний өдрийн 230-р тогтоолын 3-т Салбарын хүний нөөцийн хэрэгцээг тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлийн дагуу тодорхойлж, захиалгыг жил бүр хуучнаар БШУЯ-нд хүргүүлэхийг ЗГ-н гишүүдэд даалгасаны хэрэгжилт: А/ЗГ-ын 2024 оны 102-р тогтоолыг хавсралт журмын 4, 2025 оны 215-р тогтоолыг хавсралт журмуудад дараах байдлаар тусгасан: Үүнд: ЗГ-ын тэтгэлгийг 4, Зарим эрэлттэй мэргэжлийг 7, Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн зээлийг 10-д, 2024 оны 103-р тогтоолоор багшийн хөтөлбөрийг тус тус тусгаж, БЯ--р сангийн төсөвт багтаан хяналтын тоо батлуулан	Хэрэгжсэн	Хэрэгжсэн	

			Амгаланд;	хэрэгжүүлэн ажиллаж байна. 2.ТАХ-ын чадавхижуулах хүрээнд хэлний бэлтгэлтэй сургалтыг журамд нарийвчлан тусгасан. 3. ААНОАТ-ын нийгмийн хариуцлагын хүрээнд Боловсролд зарцуулсан хөрөнгийн 1%-ийн хөнгөлөлт эдлэх, сангийн бусад эх үүсвэрийг бий болгох зэрэг эрх зүйн орчин бүрдүүлсэн. Мөн гадаадын сургалтад сангийн хөрөнгөөр суралцуулах, төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдээс дээд боловсролын санхүүжилт хэлбэрээр олгож байгаа санхүүгийн дэмжлэгийг нэгтгэх зохион байгуулалтын арга хэмжээ авахад тус тус одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа эрх зүйн зохицуулалтыг нь өөрчлөх замаар шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна. 4.БЗС-г Боловсролын хөгжлийн сан болгох асуудлаар 2025 оны 3-р сард Ерөнхий сайдад танилцуулан Боловсролын жилийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.			
--	--	--	-----------	---	--	--	--